



ЧУХАЛ СЭДЭВ

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ

2022 ОНЫ 12 ДУГААР САР

“МӨРДӨН ШАЛГАХ НУУЦ АЖИЛЛАГАА” ТЭМДЭГЛЭЛ

АРГА ЗҮЙ

Нээлттэй Нийгэм Форум нь эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг бодлогын хэлэлцүүлэг, судалгаагаар дэмжиж ажиллахыг зорьдог билээ. Энэ хүрээнд хүний эрхэд суурилсан, шударга процесс бүхий эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор “Эрүүгийн процесс ба Хүний эрх” цуврал хэлэлцүүлгийг эхлүүллээ. Эдгээр хэлэлцүүлэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэд хэдэн хуулийн төслийг УИХ хэлэлцэж байгаа үетэй давхцаж буйгаараа онцлог юм. Цуврал хэлэлцүүлгийн зорилго эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шатанд тулгамдаж буй хүний эрхийн асуудлыг хөндөхөд оршиж байгаа бөгөөд хэлэлцүүлгийг ХЭҮК, ХЗДХЯ, МХХ, МӨХ-той хамтран зохион байгуулж байгаа билээ. Энэ удаагийн хэлэлцүүлэг Мөрдөн шалгах нууц ажиллагааны хүрээнд өрнөсөн бөгөөд түүний тэмдэглэлийг сийрүүлэн Та бүхэнд хүргэж байгаадаа баяртай байна.

МӨРДӨН ШАЛГАХ НУУЦ АЖИЛЛАГАА

ЕРӨНХИЙ ТОЙМ

Эрүүгийн эрх зүйн шинэчлэл 1993 оноос эхэлж, энэ хугацаанд хоёр удаа эрүүгийн хууль тогтоомжийг шинэчлэн найруулж баталсан бөгөөд шинэчлэлийг гүнзгийрүүлэх ажил үргэлжлэн явагдаж байна. Уг шинэчлэлийн хүрээнд мөрдөн шалгах нууц ажиллагааг нарийвчлан зохицуулсан нь хүний эрхэд нийцсэн алхам болсон билээ. Тиймээс тус зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгааг энэ хэлэлцүүлгээр хөндөж, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийг зорилоо.

“НАРАН ЦАМХГИЙН ХЭРЭГ” ЖҮЖГИЙН ТАНИЛЦУУЛГА¹

Монгол Улсад “эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа” гэдэг ойлголт хэвшсэн байсан бөгөөд үүний суурь нь эрүүгийн процессын социалист тогтолцоо буюу зарим хүмүүсийн нэрлэдгээр “Вышинскийн систем” гэх тогтолцоо билээ. Энэ нь хэргийг нотлох хамгийн гол арга хэрэгсэл бол байцаалт гэж үздэг тогтолцоо юм. Тиймээс тухайн үеийн тогтолцоонд байцаалт явуулах нь үндсэн арга хэрэгсэл, харин мөрдөн байцаалтын туршилт, нэгжлэг, үзлэг, нүүрэлдүүлэн байцаах арга хэмжээ зэрэг нь туслах чанарын арга барил байсан. Энэ тогтолцооноос салахын тулд хэргийг нотлох бусад арга хэрэгслийг хуульчлах шаардлага бий болсон. Хэргийг нотлох бусад арга хэрэгслийн нэг нь нууц мөрдөн шалгах ажиллагаа буюу “гүйцэтгэх ажил” гэж өмнө нь нэрлэгдэж байсан ажиллагааг хуульд заасан үндэслэлийн дагуу тодорхой эрх бүхий албан тушаалтан шүүгч, прокурорын зөвшөөрөлтэйгөөр нууцаар явуулж хэргийг нотолдог арга бөгөөд энэ нь дэлхий нийтэд нэгэнт жишиг болчихсон арга хэрэгсэл юм. Мөн заавал нууцаар явуулах биш, ил явуулдаг олон арга хэрэгсэл ч бий. ЭХХШТХ-д нууц мөрдөн шалгах ажиллагааг хуульчилж, энэ ажиллагааг прокурорын зөвшөөрөлтэйгөөр явуулахаар, уг ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн эсэх, ажиллагааг хууль бусаар явуулсан эсэх, явуулах үндэслэлтэй эсэх, албадлага, хүч хэрэглэсэн шинж байгаа эсэх, эрүү шүүлт тулгасан эсэх зэргийг прокурор хянахаар зохицуулсан. Харамсалтай нь үүнтэй зэрэгцээд “гүйцэтгэх ажил” гэдэг уламжлалт нэр томьёо, процесс хэвээр үргэлжлээд байгаагийн улмаас нотолгооны ач холбогдолгүй, нотлох баримтад тооцогдохгүй гүйцэтгэх ажил явуулж хүний эрх, эрх чөлөөг зөрчдөг, үүнд тавих эрх бүхий албан тушаалтны хяналт сул, үндсэндээ хянах бараг боломжгүй процесс явагдаж, улмаар үүнийг хэрэг хянан шийдвэрлэж буй шүүгчид нөлөөлөх байдлаар явуулж байгаа нь ажиглагдсан. Үүний нотолгоо нь хэрэгт авагдсан ил мөрдөн шалгах ажиллагаа болон нууцаар явуулсан мөрдөн шалгах ажиллагааны явцад хэргийг нотолсон баримт байхгүй байхад шүүх шүүгдэгчийг гэм буруутайд тооцож шийдэж байгаа явдал юм. Энэ нь олон нийтийг гайхшируулаад байгаа учраас бид өнөөдөр энэхүү нууц мөрдөн шалгах ажиллагаа гэж юу болох, уг ажиллагаа яаж явагдах ёстой, үүнтэй холбоотойгоор гүйцэтгэх ажлыг хэрхэн хязгаарлах талаар хэлэлцэж, үндэсний аюулгүй байдлыг хангахаас өөр тохиолдолд хууль сахиулах байгууллага гүйцэтгэх ажил хийсэн бол дараа нь дахин нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах юм шиг парадокс нөхцөл байдал үүсээд байгааг таслан зогсоох шаардлагатай байна.

¹ Б.Батзориг, С.Энхцэцэг. “Наран цамхгийн хэрэг” теле жүжиг. Нээлттэй Нийгэм Форум, Глоб Интернэшнл төв, МҮОHT, https://www.youtube.com/watch?v=ucdBjNd3H0k&ab_channel=OpenSocietyForum-Studio

Хоёр. МӨРДӨН ШАЛГАХ НУУЦ АЖИЛЛАГАА БА ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

Тэртээ нэг мянга есөн зуун гуч, дөч, тавь, жар, далаад он гэсэн маш урт хугацаанд мөрдөн шалгах нууц ажиллагааны хэлбэр, төрлийг хуулиар биш журмаар тогтоож ирсэн. Тухайлбал, 1932, 1937 оны Сайд нарын зөвлөлийн болон БНМАУ-ын тухайн үеийн Ардын Их Хурлын төлөөлөгчдийн шийдвэрээр байгуулсан Чойбалсан тэргүүтэй нөхдийн толгойлж байсан Комисс яргалах, тамлах, шаналгах зэргээр хэрэг улайлгаж хүлээлгэх тушаалуудыг удаа дараа гаргаж, гуч, дөчин мянган хүнийг хэлмэгдүүлсэн. Энэ мэтчилэн төрийн хууль дээдлэх зарчим үндсэндээ алдагдаж, хэн ч мэдэхгүй “маш нууц” гэсэн тушаал, заавраар хэн нэгнийг нийгмийн дайсан болгож, мөрдөн мөшгөж, хилсээр хэлмэгдүүлж ирсэн түүхийн гашуун туршлагыг ахин давтахгүй байх үүднээс 1992 оны ардчилсан Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, одоогийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар холбогдох зохицуулалтыг алхам алхмаар хуульчилж ирсэн.

Бид түүхийн энэ их алдаа нугачаануудаас сургамж авсан атлаа өнөөдөр хүртэл Гүйцэтгэх ажлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан заавар журмыг удирдлага болгон тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг явуулсаар байна. 2017 оны ЭХХШТХ-ийн мөрдөн шалгах нууц ажиллагаатай холбогдох институт бол үндсэндээ Үндсэн хуулийн 1.2-т заасан “ардчилсан ёс..., тэгш байдал,... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны зарчим мөн” гэсэн заалтыг нэг мөр хэрэгжүүлэх үүднээс Гүйцэтгэх ажлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журмаар гэмт хэрэг мөрддөг, хэн ч мэддэггүй технологиор тодорхой төрлийн нууц, далд арга хэрэгсэл, хүн хүч, техник хэрэгсэл ашиглах замаар олж авсан баримтат мэдээллийг шүүхэд “сюрприз болгох” замаар хүнийг яллах хэрэгсэл болгоод байсныг халахыг зорьсон. Энэ том алхмыг бид зоригтой хийсэн хэр нь амьдрал дээр хуулийн зорилт хэрэгжихгүй байгааг сонирхолтой кэйс баримт батлан харуулж байна. Энэ нь мөрдөн шалгах нууц ажиллагаа болон гүйцэтгэх ажлын ялгааг тодорхой зааглаж өгөөгүтэй холбоотой байж болох юм. Нөгөө талаас, гэмт хэрэг илрэхгүй байгаа нь “мөрдөн шалгах нууц ажиллагаа” гэх ажиллагаагаар мөрдөгчдийн гарыг мухарласан гэх хуучин арга барилаа санагалзах хандлагатай холбоотой.

Хэдийгээр эрх зүйн шинэчлэлийн хувьд том алхсан ч эрх зүйн зөрчлийн хамгийн хүнд хэлбэр болох гэмт хэрэг гэх үзэгдэлтэй тэмцэх хамгийн хүчирхэг хэрэгсэл бол гүйцэтгэх ажил гэж үздэг үзэл санаа одоо болтол амь бөхтэй оршиж байгааг анхаарахгүй орхих аргагүй. Мөрдөн шалгах нууц ажиллагааг ЭХХШТХ-аар нарийвчлан зохицуулсны учир бол хүний эрхэд нийцсэн эрүүгийн процессыг бэхжүүлж, улмаар энэ процессын явцад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр эрхийг зөрчихгүй байх баталгаа бүрдүүлэхийг зорьсон хэрэг юм. Ингэснээр Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр хамгаалагдсан эрхийг хангах боломжтой. Тиймээс мөрдөгчид хуульд заасан үндэслэл, журмын дагуу зөвшөөрлөө аваад мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулснаар прокурорын болон мөрдөн шалгах тусгай агентуудын авсан нотолгоо баримтууд нь шүүх дээр хүнийг яллах, цагаатгах нотолгооны эх сурвалж болох боломжтой болно. Зарим улсын эрүүгийн процессын хуульд “мөрдөн шалгах тусгай ажиллагаа” гэж томъёолсон туршлагыг харгалзан үзэж, “нууц ажиллагаа” гэхээсээ илүү “тусгай ажиллагаа” хэмээн томъёолж болох юм.

Шүүхийн шатанд гүйцэтгэх ажлын чиглэлээр олж авсан баримт, мэдээллийг гэнэт гаргаж ирэн хүнийг яллах хэрэгсэл болгоод байгааг таслан зогсоох үүднээс эрүүгийн процесст эрс шинэчлэл хийж мөрдөн шалгах нууц ажиллагааг хуульчилсан нь хүний эрхийн томоохон ахиц дэвшил юм. Өөрөөр хэлбэл, мөрдөн шалгах нууц ажиллагаа процесстой, харин гүйцэтгэх ажил заавраар явж байгаа бөгөөд заавар нь бидэнд ил биш учир процессгүй гэж хэлж болно.

ОРОЛЦОГЧДЫН БАЙР СУУРЬ

Мөрдөн шалгах нууц ажиллагаа бол нотлох баримт цуглуулах том суурь ажил юм. Энэ ажиллагаа прокурорын хяналтад явагдаж байгаа.

Эрүүгийн процессын хуулийн өөрийнх нь оршин тогтнож байгаа хамгийн чухал суурь зарчим бол хүний эрх, эрх чөлөө. Суурь зарчмыг ярихгүйгээр аливаа ажиллагааг ярих боломжгүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбоотойгоор мөрдөн шалгах нууц ажиллагааны журмыг шинээр тогтоогоогүйд асуудал оршиж байна. Энэ журмаар зөвхөн мөрдөн шалгах нууц ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах нь чухал. АНУ-д тусгай ажиллагааны журам нь ил байдаг.

Мөрдөн шалгах нууц ажиллагааг ашиглан нотлох баримт цуглуулахдаа гэмт хэргийн шинжтэй үйлдлийг газар дээр нь тогтоох зорилгоор гэмт хэрэгтэнд захиалга өгөх, хамтран ажиллаж байгаа мэтээр идэвхжүүлэх нөхцөл үүсдэг. Ингэснээр төр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бус, гэмт хэрэгт татан оруулж байгаа нь хүний эрх зөрчиж буй хэрэг бөгөөд энэ нь хуулийн зарчимтай нийцэхгүй байна.

Мөрдөгч, прокурорыг хянах хөндлөнгийн байгууллагын хяналт байх ёстой.

Сэтгэлгээ өөрчлөгдөөгүй цагт юу ч өөрчлөгдөхгүй. Сэтгэлгээ нь бас реформын үр дүнд өөрчлөгдчихгүй юм байна гэдгийг өнгөрсөн хугацаа батлан харууллаа.

Хэдийгээр хүний эрхийн асуудал байгаа ч хүний эрх зөрчигдсөн тохиолдолд эрхийг нь хамгаалах, сэргээхийн тулд явагдаж байгаа ажиллагааг ил болгож болохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Анх хууль баталж байх үед гүйцэтгэх ажлыг халж, тагнуулын ажиллагаа, тагнуулын байгууллагад өөр дэг журам үйлчлэхээр зохицуулахыг зорьсон. Өөрөөр хэлбэл, энэ нь тагнуулын байгууллагаас үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор явуулж байгаа нууц ажиллагааг “тагнуулын ажил” гэдэг нэр томъёогоор тусад нь зохицуулж, харин хууль сахиулах байгууллагын хувьд мөрдөн шалгах нууц ажиллагаагаар явуулья гэсэн үзэл баримтлал юм. Гэвч ЭХХШтХ-тай зэрэгцээд Гүйцэтгэх ажлын тухай хууль үйлчилж байгаа нь өнөөдрийн бэрхшээлийг үүсгээд байна.

Гурав. ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

ЭХХШтХ-д тун чухал шинэчлэл хийсэн ч Гүйцэтгэх ажлын тухай хууль зэрэгцэн үйлчилж байгаа нь асуудал дагуулж байна. Тиймээс цаашид Гүйцэтгэх ажлын тухай хууль гэж бие даасан тусдаа хууль байх биш, шаардлагатай гэж үзвэл үүнийг тагнуулын байгууллагын хуульдаа оруулж, харин гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагдах ёстой. Гүйцэтгэх ажил гэдэг зүйлийг бид халж байж л нууц мөрдөн шалгах ажиллагаа утга учиртай болно.

Монгол Улсын эрх зүйн орчинд “нотлох баримт” гэх ойлголт тогтворгүй, төлөвшилгүй байна. Тухайлбал, иргэн, захиргаа, эрүүгийн хэргийн нотлох баримт тус тусдаа ухагдахуун болоод хөгжчихсөн. Үүнээс гадна аливаа эрх зүйн маргаан, асуудлыг шүүхийн бус журмаар шийдвэрлэдэг орчинд нотлох баримтын тухай тэс өөр ойлголт бий. Нотлох баримтын тухай олон янзын ойлголт явж байтал энэ дунд дахиад нууц мөрдөн шалгах ажиллагааны үр дүн, гүйцэтгэх ажлын үр дүн, гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээ, баримт сэлт гэдэг ухагдахуун бий болсон. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нотлох баримтын шаардлагыг мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад хангах байтал үүнийг шүүгч, прокурор нь шаардахаа мэддэггүй. Энэ бол маш ноцтой асуудал юм. Мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн нотлох баримтаар тооцогдоход ил явагдсан мөрдөн шалгах ажиллагаатай адил стандарт шаардлага тавигдах ёстой. Гэтэл энэ нь нууц явж байгаа учир гээд үр дүнг нь ерөөсөө хүнд үзүүлэхгүй, мөрдөгчийн магадалгаа гэдэг зүйл бичээд байна.

“Нууц мөрдөн шалгах ажиллагааг ямар арга хэрэгслээр хийсэн нь нууц байх ёстой, үүнд мэргэжлийн удирдлага нь хяналт тавина” гэж зохицуулсан. Нэг талаас энэ нь зөв юм шиг боловч нөгөө талаасаа энэ байгууллага дотооддоо ямар хууль, дүрэм журам баримталж байгаа, түүнийгээ мөрдсөн эсэхийг даалгавар өгсөн дарга нь хянаж байгаа эсэх, мөн энэ явцад хууль бус, зөрчилтэй үйлдэл халхлагдсан эсэхийг ярих боломжгүй болчихоод байгаа учир мөрдөн шалгах нууц ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлагатай. Мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад прокурор хяналт тавихын тулд тухайн байгууллагын дотоод болон мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахтай холбоотой дүрэм журмууд прокуророор хянагддаг байх нь маш чухал юм.

Хамгийн гол нь 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж бий болох ёстой байсан дэд бүтцүүд бий болоогүйн улмаас өнөөгийн хүндрэл үүсэж байна. Эрүүгийн процессын гол шинэчлэл, өөрчлөлт бол наад зах нь цахим хэлбэрээр мэдүүлэг авах явдал юм. Ний нуугүй хэлэхэд эрүүгийн процессын шинэ хуулийн хүрээнд бий болох байсан дэд бүтцүүд, техник технологи байхгүйн зэрэгцээ хүний нөөцийн чадамж сул, тэр ч байтугай сэтгэлгээ бэлэн биш байгаа нь гэмт хэрэг илрүүлэхэд садаа болж байна. Технологийн тусламжтай илрүүлж болох зүйлсийг бид нөгөө л хуучин арга барилдаа тулгуурлан илрүүлэх гээд зүтгэсэн хэвээр байна. Мөн эрүүгийн эрх зүйн шинэтгэлтэй холбогдуулан Дотоод хэргийн их сургуульд нарийн мэргэжил эзэмшсэн хүмүүсийг мэргэшүүлэн сургаж, хоёр жилийн хугацаанд мөрдөгч, шинжээч гэх мэргэжлээр төгсгөсөн. Гэтэл нарийн мэргэжлийн эдгээр мэргэжилтнийг хөтөлбөрт анх элсүүлсэн зорилгоороо ажиллуулахгүй байна.

Мөрдөн шалгах нууц ажиллагаа нь хүний наймаа, хар тамхины гэх мэт зохион байгуулалттай, маш ноцтой хэрэг илрүүлэхэд ач холбогдолтой. Учир нь ердийн арга хэрэгсэл ашиглаад илрүүлэх боломжгүй болж мухардалд орох үед мөрдөн шалгах ажиллагааг нууцаар явуулах зайлшгүй шаардлага бий болох бөгөөд энэ нь зүй ёсны үндэслэл юм. Нөгөө талаасаа мөрдөн шалгах нууц ажиллагаа нь хүний эрхэд хамгийн их халддаг зүйл. Монгол Улсын соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17-р зүйлд хувийн амьдрал халдашгүй байх эрхийг заасан. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13-т “Хувийн халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэсэн. Хүний эрхийг дээдлэх нь орчин үеийн нийгмийн маш чухал үнэт зүйл бөгөөд хүн өөрийнхөөрөө амьдрах, өөрийн амьдралтай холбоотой хувийн шийдвэрээ гаргах, хэний ч хараа хяналтгүй өөрийнхөөрөө байх орон зай, хувийн нууцыг хамгаалах зэрэг нь хувь хүний хувьд маш чухал. Эндээс хувийн халдашгүй байх эрх болон гэмт хэрэг илрүүлэх зорилт хоёрын тэнцвэрийг хэрхэн хангах вэ гэдэг нь гол асуудал юм.

Тиймээс мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулж байгаа байгууллага, албан тушаалтан Үндсэн хуулийн зарчмыг баримтлаад явбал хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх боломжтой. Үүнтэй холбогдуулан гурван зүйл дурдах нь зүйтэй. Нэгдүгээрт, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13-т “...хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч мөрдөн мөшгөхийг хориглоно” гэж заасан. Мөрдөн мөшгөлгийн нэг хэлбэр бол мөрдөн шалгах нууц ажиллагаа юм. Үндсэн хуульд туйлын тодорхой байдлаар, энэ ажиллагааг ямар үндэслэлээр, ямар журмаар явуулахыг хуульд заана гэсэн шаардлага тавьсан. Үндсэн хуулийн 1-р зүйлийн 1.2-т хууль дээдлэх зарчмыг тусгасан. Тиймээс хүний эрхэд халдах ямар нэгэн ажиллагаа байгаа бол үндэслэл нь заавал хуульд бичигдэх ёстой. Мөн дур зоргоороо, үзэмжээр хандахаас сэргийлж, маш тодорхой бичих ёстой. Харамсалтай нь өнгөрсөн хугацаанд ч, шинэ хуулиар ч энэ шаардлага хангагдаагүй. Тухайлбал, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах үндэслэл, журмыг ерөнхий байдлаар хуульд тусгаад нарийвчилсан журмыг улсын ерөнхий прокурор, тагнуулын ерөнхий газрын дарга хамтарч батлахаар зохицуулсан. Харамсалтай нь энэ журам хэнд ч олддоггүй. Хэдийгээр нууц ажиллагаа явуулах арга тактиктэй

холбоотой зүйлс нууц байж болох ч ямар гэмт хэрэгт, хэдий хугацаанд энэ ажиллагааг явуулах, хугацаа нь дуусахаар хэрхэх талаарх асуудлыг журамласан шийдвэрийг олж мэдэх боломжгүй байгаа нь Үндсэн хууль зөрчсөн хэрэг юм. Үүнийг засах ёстой.

Хоёрдугаарт, үндэслэл, журмыг хуульдаа хэрхэн бичих тухай асуудал юм. Өмнө дурдсанчлан гэмт хэргийг илрүүлэх төрийн үүрэг, нөгөө талаас хувийн халдашгүй байх эрх хоёрын тэнцвэрийг олох нь чухал бөгөөд Үндсэн хуулийн 1-р зүйлийн 1.2-т заасан шударга ёсны зарчмыг баримтлах ёстой. Шударга ёсны зарчмын үүднээс авч үзвэл ял шийтгэл нь гэмт хэрэгт тохирсон байхын зэрэгцээ тухайн авч байгаа арга хэмжээ хүний эрхэд халдах гэж байгаа бол хууль ёсны зорилгодоо хүрэхэд тохирсон байх гэсэн утга илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, энэ нь “пропорционал” (proportionality) гэсэн зарчим юм. Монгол хэлээр үүнийг “тохирсон байх”, “пропорционал байх”, “хувь тэнцүүлэх” гээд янз бүрээр орчуулдаг. Гэвч эрүүгийн хууль тогтоомжид орж ирсэн уламжлалаар бол “пропорционал” гэдэг нь тохирсон байх зарчим юм. Тухайлбал, Эстони улс мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах үндэслэл журмыг бүхэл бүтэн бүлгээр зохицуулсан бөгөөд маш нарийн зохицуулсан эрүүгийн процессын хуультай. Ийнхүү хуулиар нарийвчлан зрхицуулах нь ажиллагаа явуулсны дараа буруутгагдахгүй, янз бүрийн асуудал үүсэхгүй байх талаасаа ажиллагаа явуулж байгаа хүмүүстээ ч амар юм.

Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахад баримтлах хэд хэдэн зарчим байна. Нэгдүгээрт, ямар хэрэг дээр явуулах талаар олон улсын нийтлэг жишиг байдаг. Энэ ажиллагааг таван жилээс дээш хорих ялтай, зөвхөн онц ноцтой, ер нь хүнд үр дагавартай хэргүүд дээр л явуулахаар зохицуулдаг. Учир нь хүний эрхэд хамгийн их халддаг арга хэрэгсэл учраас үүнийг бүх хэрэгт нийтлэг байдлаар хэрэглэхээс татгалздаг. Хоёрдугаарт, ердийн арга хэрэгслээр баримт мэдээлэл цуглуулах оролдлого хийсэн ч бүтээгүй тохиолдолд л эцсийн арга болгож хэрэглэх ёстой. Гуравдугаарт, хугацаа тодорхой байх ёстой. Одоогийн эрүүгийн процессын хуульд хугацаа байхгүй, “Прокурор зөвшөөрөл өгнө” гээд л орхисон. Журам нь нууц тул хугацааны талаар хэрхэн зохицуулсныг мэдэх боломжгүй байна. Тиймээс хугацаа тогтоох, хугацааг хэрхэн сунгах талаар нарийвчлан зохицуулах ёстой. Энэ нь хуульд байх ёстой.

Мөн Үндсэн хуулийн 1-р зүйлийн 1.2-т заасан эрх чөлөөний зарчим нь цаанаа эрх чөлөөний баталгаа шаардаж байдаг. Өөрөөр хэлбэл, үндсэн эрхийг хүмүүст байна гэж үзэх ёстой болохоос бус, төр өгч байгаа хэрэг биш юм. Тиймээс энэ эрхийг зайлшгүй нөхцөлд л хязгаарлахын зэрэгцээ аль болохоор эрхийг нь эдлүүлэх зарчим баримтлах ёстой. Тухайлбал, нэг хүний утсыг тагнаж, чагналаа гэхэд гуравдагч этгээдийн яриаг аль болох чагнахгүй байх ёстой. Нөгөө талаар гэмт хэрэг илрүүлэхэд шаардлагатайгаас бусад хувийн зүйл рүү орж болохгүй. ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн 2008 оны шийдвэрт “Ийм ажиллагаа хийх бол хувийн зүйл рүү орох ёсгүй бөгөөд төрийн ёс зүйг баримтлах ёстой” гэж дурдсан. Энэ мэт зарчим хуульд бичигдэх ёстой ч харамсалтай нь тэр бүр бичигддэггүй.

Мөн мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулж байхад хэрэг нь хэрэгсэхгүй болох, буруутгагдаж байсан хүн цагаатгагдвал гарах үр дагаврыг зохицуулсан зохицуулалт бас байхгүй. Тухайлбал, хэрэг нь цагаатгагдвал мэдээллийг устгах ёстой. Өөр нэг асуудал бол цугларсан мэдээллийг хэрхэн хамгаалах талаар зохицуулалт дутмаг. Гэм буруугүй нь шат шатны шүүхээр тогтоогдсон тохиолдолд тухайн мэдээллийг тодорхой хугацаа өнгөрсний дараа устгах ёстой. Учир нь тэр мэдээллийг хэн нэгэн олж аваад өөр зорилгоор ашиглахаас сэргийлж буй хэрэг юм. Бидний мэдэж байгааг хүний хувийн мэдээлэл гэнэт л гараад ирдэг, мэдээллийг харахад мэргэжлийн хүмүүс оролцсон байхаар сэжиг, таамаг төрдөг. Энэ нь нэг талаас тухайн мэргэжлийн ажил хийж байгаа хүмүүсийн нэр хүндэд халтай. Тиймээс энэ асуудлыг шийдэх нь зүйтэй.

Гуравдугаарт, мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад шүүхийн хяналт заавал байх ёстой. Энэ бол ардчилсан улсын жишиг. Жишээлбэл, баривчлах, цагдан хорих зөвшөөрлийг өмнө нь шүүх

өгдөггүй байсныг шүүх рүү шилжүүлсэн. Гэвч мөрдөн шалгах нууц ажиллагааны хяналтыг шүүхэд өгснөөр энэ асуудал бүрэн шийдэгдэхгүй. Мөрдөн шалгах нууц ажиллагааны журмыг хуулиар нарийвчлан зохицуулж, үндэслэлийг нь маш тодорхой бичих шаардлагатай. Энэ ажиллагааны зөвшөөрлийг шүүх рүү шилжүүлэх гол шалтгаан нь шүүгч гэх мэргэжлийн байр суурь нь төвийг сахисан, хэн нэгнээс хараат бус, зөвхөн хуульд захирагддагтай холбоотой. Тиймээс Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13-т заасан “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэснийг нэг мөр хэрэгжүүлэх үүднээс уг зөвшөөрлийг шүүхэд шилжүүлэх шаардлагатай.

ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

- * Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд мөрдөн шалгах нууц ажиллагаатай холбоотой үндэслэл, журмыг нарийвчлан зохицуулах;
- * Зөвшөөрлийн тогтолцоог шүүхэд шилжүүлэх;
- * Гүйцэтгэх ажлын тухай хуулийг Тагнуулын ерөнхий газрын харьяалах хэрэгт хамааралтай байхаар шинэчлэн боловсруулах;
- * Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үзэл баримтлалыг хуульч, хууль сахиулагчдад ойлгуулан таниулах ажлыг цогцоор нь зохион байгуулах.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГЧДЫН НЭРС

1. С.Гантогтох - МХХ-ны гишүүн, Эрүүгийн эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн
2. Н.Манлайбаатар - Судлаач
3. Я.Цэлмэн - ХЭҮК, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн ухааны доктор (Ph.D)
4. О.Мөнхсайхан - МУИС-ийн Хууль зүйн сургууль, хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор
5. Г.Эрдэнэбат - Хуульч

Хэлэлцүүлгийг хөтөлж,
тэмдэглэлийг сийрүүлсэн
Б.ХИШИГСАЙХАН,
ННФ-ын Эрхзүйн хөтөлбөрийн
менежер



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Хаяг: Монгол Улс,
Улаанбаатар хот-14240,
Сүхбаатар дүүрэг,
Жамьян гүний гудамж-5/1

Утас: 976-76113207
Факс: 976-11-324857
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn